



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/215-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он | ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-------|
| 1. Аудитын дүгнэлт | 4-5 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 6-12 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 13-17 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 13 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 13-14 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 14 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 14-15 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 15-17 |
| 4. Аудитын тайлан | 17-20 |
| 4.1 Ерөнхий зүйл | 17 |
| 4.2 Материаллаг байдал | 18 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 18 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 18 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 19 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19-20 |
| 5. Аудитын илрүүлэлт | 21-22 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 23 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| НА | Нийцлийн аудит |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.БҮРЭНБУЯН ТАНАА

2024.08.23 № САА-2024/215-ДН-С-Н-НУЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 7,172.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралттай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 115,219.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засвар, гадна пасадны их засварын ажлыг хийж сургуулийн барилгыг капиталжуулсан байна.

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 27,447.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|------------------|------------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 53,486,959.60 | 145,263,744.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 6,643,205.60 | 97,429,641.00 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 6,643,205.60 | 97,429,641.00 |
| 3121 | Төгрөг | 6,643,205.60 | 97,429,641.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 6,643,205.60 | 97,429,641.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 46,843,754.00 | 47,834,103.00 |
| 351 | Түүхий эд материал | 2,698,898.00 | 2,753,898.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 2,669,398.00 | 2,669,398.00 |
| 3513 | Эм боох материал | 29,500.00 | 84,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 44,144,856.00 | 45,080,205.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 2,575,451.00 | 629,900.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 799,200.00 | 636,200.00 |
| 3546 | Хүнсний материал | 1,536,000.00 | |
| 3547 | Бусад хангамжийн материал | 39,234,205.00 | 43,814,105.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,526,626,405.81 | 1,598,495,264.32 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,526,626,405.81 | 1,598,495,264.32 |
| 392 | Биет хөрөнгө | 1,431,707,655.75 | 1,503,919,014.46 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,414,166,879.00 | 1,529,386,746.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -89,064,399.24 | -115,774,831.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,921,079.46 | 65,062,144.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -26,082,383.24 | -36,708,330.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,345,516.94 | 33,010,876.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,137,470.53 | -16,769,171.44 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 67,337,844.00 | 67,337,844.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -16,779,410.64 | -21,626,263.32 |
| 393 | Биет бус хөрөнгө | 94,918,750.06 | 94,576,249.86 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,061,249.94 | -1,403,750.14 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 94,330,000.00 | 94,330,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,580,113,365.41 | 1,743,759,008.32 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 6,896,595.00 | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 6,896,595.00 | |
| 413 | Өглөг | 6,896,595.00 | |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 6,896,595.00 | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,573,216,770.41 | 1,743,759,008.32 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,573,216,770.41 | 1,743,759,008.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 400,803,767.00 | 400,803,767.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 400,803,767.00 | 400,803,767.00 |

| | | | |
|------|---|------------------|------------------|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,009,969,938.97 | 1,180,512,176.88 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 1,009,969,938.97 | 1,009,969,938.97 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 170,542,237.91 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 162,443,064.44 | 162,443,064.44 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,580,113,365.41 | 1,743,759,008.32 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------|---|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,290,435,121.48 | 1,090,585,886.74 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,608,110,454.50 | 115,319,867.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,608,110,454.50 | 115,319,867.00 |
| 1E+05 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,566,954,900.50 | 115,219,867.00 |
| 1E+05 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 41,155,554.00 | 100,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 682,324,666.98 | 975,266,019.74 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 577,233,300.00 | 885,334,600.00 |
| 1E+05 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 577,233,300.00 | 885,334,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 105,091,366.98 | 89,931,419.74 |
| 1E+05 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 105,091,366.98 | 89,931,419.74 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 717,218,351.07 | 920,043,648.83 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 717,218,351.07 | 920,043,648.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 699,610,651.07 | 902,202,548.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 431,230,348.00 | 586,623,180.65 |
| 2E+05 | Үндсэн цалин | 328,661,895.00 | 392,221,607.73 |
| 2E+05 | Нэмэгдэл | 89,334,494.00 | 161,857,259.94 |
| 2E+05 | Урамшуулал | 13,233,959.00 | 32,544,312.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,625,798.78 | 75,940,410.95 |
| 2E+05 | Тэтгэврийн даатгал | 38,481,606.53 | 49,175,945.91 |
| 2E+05 | Тэтгэмжийн даатгал | 4,183,757.16 | 6,784,808.95 |
| 2E+05 | ҮОМШӨ-ний даатгал | 3,483,114.34 | 5,752,842.08 |
| 2E+05 | Ажилгүйдлийн даатгал | 860,703.99 | 1,282,704.92 |
| 2E+05 | Эрүүл мэндийн даатгал | 8,616,616.76 | 12,944,109.09 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,170,483.60 | 77,214,824.74 |
| 2E+05 | Гэрэл, цахилгаан | 5,112,083.60 | 8,147,116.74 |
| 2E+05 | Түлш, халаалт | 33,947,700.00 | 41,786,287.00 |
| 2E+05 | Цэвэр, бохир ус | 27,110,700.00 | 27,281,421.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 2,108,551.00 |
| 2E+05 | Бараа материал акталсны зардал | | 2,108,551.00 |
| 2105 | Нормативт зардал | 75,740,050.00 | 80,406,720.00 |
| 2E+05 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 50,700.00 | |
| 2E+05 | Хоол, хүнс | 75,689,350.00 | 80,406,720.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,816,000.00 | 5,820,000.00 |

| | | | |
|-------|--|------------------|----------------|
| 2E+05 | Урсгал засвар | 7,816,000.00 | 5,820,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 782,016.00 | 1,371,000.00 |
| 2E+05 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,016.00 | 1,371,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,245,954.69 | 72,717,861.49 |
| 2E+05 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,661,525.00 | 14,342,953.00 |
| 2E+05 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,048,535.00 | 4,117,200.00 |
| 2E+05 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,535,894.69 | 54,257,708.49 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| 2E+05 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,573,216,770.41 | 170,542,237.91 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,573,216,770.41 | 170,542,237.91 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--------|---|----------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 682,324,666.98 | 975,266,019.74 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 682,324,666.98 | 975,266,019.74 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 577,233,300.00 | 885,334,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 577,233,300.00 | 885,334,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 105,091,366.98 | 89,931,419.74 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 105,091,366.98 | 89,931,419.74 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 668,474,061.38 | 873,572,884.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 668,474,061.38 | 873,572,884.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 650,866,361.38 | 855,731,784.34 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 431,230,348.00 | 586,623,180.65 |
| 210101 | Үндсэн цалин | 328,661,895.00 | 392,221,607.73 |
| 210102 | Нэмэгдэл | 89,334,494.00 | 161,857,259.94 |
| 210104 | Урамшуулал | 13,233,959.00 | 32,544,312.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,625,798.78 | 75,940,410.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,481,606.53 | 49,175,945.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,183,757.16 | 6,784,808.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,483,114.34 | 5,752,842.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 860,703.99 | 1,282,704.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,616,616.76 | 12,944,109.09 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 59,273,888.60 | 84,111,419.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,112,083.60 | 8,147,116.74 |
| 210302 | Түлш, халаалт | 33,947,700.00 | 41,786,287.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,214,105.00 | 34,178,016.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 76,588,950.00 | 78,870,720.00 |
| 210502 | Хоол, хүнс | 76,588,950.00 | 78,870,720.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,816,000.00 | 5,820,000.00 |

| | | | |
|--------|---|---------------|----------------|
| 210604 | Урсгал засвар | 7,816,000.00 | 5,820,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 782,016.00 | 1,371,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,016.00 | 1,371,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,549,360.00 | 22,995,053.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,519,425.00 | 18,877,853.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,029,935.00 | 4,117,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,607,700.00 | 17,841,100.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 13,850,605.60 | 101,693,135.40 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 7,207,400.00 | 10,906,700.00 |
| 22 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах | 7,207,400.00 | 10,906,700.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 7,207,400.00 | 10,906,700.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 7,207,400.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 10,906,700.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -7,207,400.00 | -10,906,700.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 6,643,205.60 | 90,786,435.40 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 6,643,205.60 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 97,429,641.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|-----|--|--------------------|-----------------------|----------------------|-------------------------|
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 400,803,767.00 | 162,443,064.44 | 1,009,969,938.97 | 1,573,216,770.41 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 170,542,237.91 | 170,542,237.91 |
| 19 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 400,803,767.00 | 162,443,064.44 | 1,180,512,176.88 | 1,743,759,008.32 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|----------------|----------------|----------------|---------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 990,190,400.00 | 884,479,584.34 | 105,710,815.66 | 89.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 990,190,400.00 | 873,572,884.34 | 116,617,515.66 | 88.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 972,349,300.00 | 855,731,784.34 | 116,617,515.66 | 88.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 668,540,700.00 | 586,623,180.65 | 81,917,519.35 | 87.7 |
| 210101 | Үндсэн цалин | 426,893,000.00 | 392,221,607.73 | 34,671,392.27 | 91.9 |
| 210102 | Нэмэгдэл | 207,685,700.00 | 161,857,259.94 | 45,828,440.06 | 77.9 |
| 210104 | Урамшуулал | 33,962,000.00 | 32,544,312.98 | 1,417,687.02 | 95.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 89,818,900.00 | 75,940,410.95 | 13,878,489.05 | 84.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,077,300.00 | 49,175,945.91 | 11,901,354.09 | 80.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,185,600.00 | 6,784,808.95 | 400,791.05 | 94.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,748,000.00 | 5,752,842.08 | -4,842.08 | 100.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,436,900.00 | 1,282,704.92 | 154,195.08 | 89.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,371,100.00 | 12,944,109.09 | 1,426,990.91 | 90.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 92,393,500.00 | 84,111,419.74 | 8,282,080.26 | 91.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,615,100.00 | 8,147,116.74 | -532,016.74 | 107.0 |
| 210302 | Түлш, халаалт | 48,496,000.00 | 41,786,287.00 | 6,709,713.00 | 86.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,282,400.00 | 34,178,016.00 | 2,104,384.00 | 94.2 |
| 2105 | Нормативт зардал | 80,499,400.00 | 78,870,720.00 | 1,628,680.00 | 98.0 |
| 210502 | Хоол, хүнс | 80,499,400.00 | 78,870,720.00 | 1,628,680.00 | 98.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,820,000.00 | 5,820,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,820,000.00 | 5,820,000.00 | 0.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,372,400.00 | 1,371,000.00 | 1,400.00 | 99.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,372,400.00 | 1,371,000.00 | 1,400.00 | 99.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,904,400.00 | 22,995,053.00 | 10,909,347.00 | 67.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,787,200.00 | 18,877,853.00 | 10,909,347.00 | 63.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,117,200.00 | 4,117,200.00 | 0.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,841,100.00 | 17,841,100.00 | 0.00 | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,841,100.00 | 17,841,100.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,841,100.00 | 17,841,100.00 | 0.00 | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 10,906,700.00 | -10,906,700.00 | #DIV/0! |
| | Дотоод эх үүсвэрээр | | 10,906,700.00 | -10,906,700.00 | #DIV/0! |
| 223001 | Бусад хөрөнгө | | 10,906,700.00 | -10,906,700.00 | #DIV/0! |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 990,190,400.00 | 975,266,019.74 | 14,924,380.26 | 98.5 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 885,334,600.00 | 885,334,600.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|--------|--|----------------|----------------|----------------|-------|
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 885,334,600.00 | 885,334,600.00 | 0.00 | 100.0 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 98,213,500.00 | 89,931,419.74 | 8,282,080.26 | 91.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 98,213,500.00 | 89,931,419.74 | 8,282,080.26 | 91.6 |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | 6,642,300.00 | | 6,642,300.00 | 0.0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,642,300.00 | 6,643,205.60 | -905.60 | 100.0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 97,429,641.00 | -97,429,641.00 | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 40 | 40 | - | 100.0 |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 21 | 21 | - | 100.0 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 18 | 36 | (18) | 200.0 |
| 15 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 204 | 200 | 4 | 98.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн өөрийн онцлог мөн чанарт нийцүүлэн үйлдлүүдэд хамруулан оюуны сэтгэх чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих суралцахад дэмжлэг үзүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд эрүүл бие бялдартай аливаа үйл ажиллагаанд идэвх, сонирхолтой оролцож эрүүл ахуйн зөв дадалтай болох,
- Хүүхэд өөрийн болон хүмүүсийн сэтгэл хөдлөл зан байдлыг ойлгох сэтгэлийн хөдөлгөөн, харилцаагаа эергээр илэрхийлж хүндэтгэлтэй харилцах, өөртөө итгэлтэй суралцах сонирхолтой байх.
- Хүүхэд дүрслэх урлаг, хөгжмийг сонирхож таашааж, урлагийн үйлд бүтээлчээр оролцдог байх.
- Олон улсын эко сургалтын сэдвийн хүрээнд тогтвортой хөгжлийн бодлогоос хэрэгжүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэгдэн батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1.“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, 2.“Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 163,645.6 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|--------------------|
| | | | /мянган төгрөгөөр/ |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 6,643.2 | 97,429.6 | 90,786.4 |
| Авлага | | | |
| Бараа материал | 46,843.8 | 47,834.1 | 990.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,526,626.4 | 1,598,495.3 | 71,868.9 |
| Нийт хөрөнгө | 1,580,113.4 | 1,743,759.0 | 163,645.6 |
| Өр төлбөр | 6,896.6 | - | (6,896.6) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,573,216.8 | 1,743,759.0 | 170,542.2 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,580,113.4 | 1,743,759.0 | 163,645.6 |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 97,429.6 мянган төгрөг болж 90,786.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7

дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,

- Бараа материал дансны үлдэгдэл 47,834.1 мянган төгрөг болж 990.3 мянган төгрөгөөр өссөн нь НҮБ-ын Хүүхдийн сангаас 100.0 мянган төгрөгийн сонсдог ном, төсвийн хөрөнгөөр 98,453.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б176, Б177 дугаар тушаалуудаар цаашид ашиглах боломжгүй 7,100.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж үйл ажиллагаанд 95,455.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,598,495.3 мянган төгрөг болж 71,868.9 мянган төгрөгөөр буурсан нь сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 115,219.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, дээврийн болон гадна пасадны их засвар хийж хөрөнгийг капиталжуулсан, төсвийн хөрөнгөөр 10,906.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 7,100.2 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 117 дугаар тогтоолын дагуу акталж, 47,157.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 593,949.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 98,229.2 мянган төгрөг, нийт 692,178.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 34,728.3 мянган төгрөгөөр буюу цалин хөлс, шимтгэлийн зардлыг 51,247.4 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1,840.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,470.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,982.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлыг 26,812.6 мянган төгрөгөөр бууруулж нийт 726,907.1 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин хөлс, шимтгэлийн зардлыг 227,816.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 2,350.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 15,171.3 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 5,780.8 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 17,841.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тогтмол зардлыг 5,676.2 мянган төгрөгөөр бууруулж нийт 990,190.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 990,190.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 884,479.6 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 8,282.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 97,429.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 884,479.6 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 95,800.0 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 1,628.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 8,282.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр зориулалт | Нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|--------------------|---------------------------------------|------------------|------------------|------------------|-------------|
| 1 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 2,382.6 | 2,380.0 | 2.6 | 99.9 |
| 2 | 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 80,499.4 | 78,870.7 | 1,628.7 | 98.0 |
| 3 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 4,232.6 | 4,232.6 | 0.0 | 100.0 |
| 4 | 81823 | Боловсролын байгууллагын багш, | 2,058.6 | 2,058.6 | 0.0 | 100.0 |
| 5 | 81834 | Боловсролын стандарт, сургалтын | 527,158.9 | 455,542.4 | 71,616.5 | 86.6 |
| 6 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 275,644.8 | 251,463.9 | 24,180.9 | 91.2 |
| 7 | 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 98,213.5 | 89,931.4 | 8,282.1 | 91.0 |
| | | Нийт | 990,190.4 | 884,479.6 | 105,710.8 | 89.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланг худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 74,718.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан боловч, оролцогч

ирээгүйгээс “Эх наран булаг” ХХК “Шанзан ташуур” ХХК, “Шинэ шүүдэр” ХХК, “Уужим хараа” ХХК, “Ноцох дөл” ХХК-иудтай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 717,218.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,172.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илэрсэнгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 224 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивээгүй 1,012.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 1 албан шаардлага өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | | | | | |
| Албан шаардлага | 1 | 1,012.5 | 1 | 1,012.5 | 100.0 |
| Нийт дүн | 1 | 1,012.5 | 1 | 1,012.5 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй балансын урамшуулал гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу 868.1 мянган төгрөгийн урамшууллыг нярав С.Шинэбаярт давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар **12,223.9** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх 5,336.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 6,887.4 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Жилийн эцэс буюу тайлант оны 9-12 дугаар саруудад ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэлгүйгээр бүх багш нарт тус бүр 25.0 хувиар тооцон, нийт **5,336.5** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно” “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан цалингийн зардлаас 9 багшид “Чадварлаг багш” хөтөлбөрт тэргүүн байр эзэлсэн, “Байгууллагын шилдэг ажилтан”, “Тэргүүн номинаци” “Чадварлаг багш” хөтөлбөрийн дэд байрт шалгарсан гэх үндэслэлүүдээр шагналын зардалд **6,887.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож олгоогүй | 1 | 5,336.5 | 1 | 5,336.5 | | | | | | | | |
| Цалингийн зардлыг гүйлгэн зарцуулсан | 1 | 6,887.4 | | | 1 | 6,887.4 | | | | | | |
| Дүн | 2 | 12,223.9 | 1 | 5,336.5 | 1 | 6,887.4 | | | | | | |